МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО
MONGOLIAN AMATEUR SWIMMING FEDERATION

Founded in 1991
Affiliated to FINA, 1996
Affiliated to AASF, 2000

Mongolia. Ulaanbaatar, Khan-uul district,
National Olympic committee building, Room 115
Tel: (976)-88131777, (976)-99131777
Email: secretariat@mongoliaaquatics.mn
Web: www.mongoliaaquatics.mn

2026 оны 10-р сарын 23-ны өдөр № 16 Улаанбаатар хот

УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

УЗ-ийн дэргэдэх мэрэгжлийн зөвлөлүүдийг сонгох
сонгуулийн комиссын бүрэлдэхүүн болон
сонгуулийн түр журмыг батлах тухай

"Монголын усан спорт сонирхогчдын холбоо" төрийн бус байгууллага ("**Холбоо**" гэх)-ын Удирдах зөвлөлийн хурлаас Холбооны дүрмийн 15.1-т "Холбооны Удирдах Зөвлөлийн дэргэд дараах Зөвлөл, баг ажиллана" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Холбооны Удирдах зөвлөлийн дэргэдэх Зөвлөлүүдийг байгуулах сонгуулийн комиссын бүрэлдэхүүнийг энэхүү тогтоолын Хавсралт-1 ёсоор баталсугай.

2. Холбооны мэргэжлийн зөвлөлүүдийг байгуулах, сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах түр журмыг энэхүү тогтоолын Хавсралт-2 ёсоор баталсугай

3. Холбооны мэргэжлийн зөвлөлд нэр дэвшигчийн анкетыг энэхүү тогтоолын Хавсралт-3 ёсоор баталсугай.

4. Холбооны мэргэжлийн зөвлөлийг байгуулах хурлын төлөөлөгчдийн анкетыг энэхүү тогтоолын Хавсралт-4 ёсоор баталсугай.

5. Мэргэжлийн зөвлөлүүдийг байгуулах хурлыг 2026 оны 11 сарын 22-ны дотор зохион байгуулахыг сонгуулийн комисст даалгасугай.

6. Мэргэжлийн зөвлөлүүдийн сонгуулийн үр дүнг дараагийн Удирдах зөвлөлийн хуралдаанд танилцуулж батлуулахыг ЕНБД-д үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ Р.БАДРАХ

МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО
MONGOLIAN AMATEUR SWIMMING FEDERATION

Founded in 1991
Affiliated to FINA, 1996
Affiliated to AASF, 2000

Mongolia. Ulaanbaatar, Khan-uul district,
National Olympic committee building, Room 115
Tel: (976)-88131777, (976)-99131777
Email: secretariat@mongoliaaquatics.mn
Web: www.mongoliaaquatics.mn

Удирдах зөвлөлийн 2026 оны 10 сарын 23-ны өдрийн
16 тоот тогтоолын Хавсралт-1

Мэргэжлийн зөвлөлүүдийг байгуулах сонгуулийн комиссын бүрэлдэхүүн

№	Зөвлөлийн нэр	Комиссын дарга	Комиссын гишүүд
1.	Тамирчдын зөвлөл	Дэд Ерөнхийлөгч Ө.Үнэнбүрэн	Хяналтын зөвлөл- А.Энхбаяр ЕНБД
2.	Дасгалжуулагчдын зөвлөл	Тэргүүн Дэд Ерөнхийлөгч Ж.Энхтөр	Хяналтын зөвлөл- Д.Батсүх ЕНБД
3.	Шүүгчдийн зөвлөл	Дэд Ерөнхийлөгч Ц.Баяраа	Хяналтын зөвлөл- Ч. Бумдарь, ЕНБД
4.	Ёс зүйн зөвлөл	Дэд Ерөнхийлөгч С. Сайнбат	Хяналтын зөвлөл- Д.Батсүх ЕНБД

“МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБОО” НҮТББ-ЫН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДЭРГЭДЭХ МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛҮҮДИЙГ БАЙГУУЛАХ, СОНГУУЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ТҮР ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү Түр журмын зорилго нь Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбоо (цаашид “Холбоо” гэх)-ны Дүрэм болон Удирдах зөвлөлийн дэргэдэх мэргэжлийн зөвлөлүүдийн үйл ажиллагааны журмын хүрээнд мэргэжлийн зөвлөлүүдийг шинээр байгуулах, тэдгээрийн гишүүдийг сонгох, сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах, үр дүнг баталгаажуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Энэхүү Түр журам нь Холбооны Дүрэм, тухайн мэргэжлийн зөвлөлийн хүчин төгөлдөр мөрдөж буй журам, Удирдах зөвлөлийн шийдвэрт нийцсэн байна.

1.3. Түр журмын хүрээнд дараах мэргэжлийн зөвлөлүүдийг байгуулах ажлыг зохион байгуулна Үүнд:

1.3.1. Тамирчдын зөвлөл;

1.3.2. Дасгалжуулагчдын зөвлөл;

1.3.3. Шүүгчдийн зөвлөл;

1.4. Сонгуулиар бүрдүүлэхээр заагаагүй зөвлөлийн хувьд энэхүү Түр журмыг үндэслэн сонгууль явуулахгүй.

1.5. Сонгуулийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

1.5.1. Хууль ёсны, дүрэмд нийцсэн байх;

1.5.2. Шударга, хараат бус, ил тод байх;

1.5.3. Нэр дэвшигчдэд тэгш боломж олгох;

1.5.4. Сонгогчдын чөлөөт сонголт, нууц санал хураалтыг хангах;

1.5.5. Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

1.5.6. Сонгуулийн баримт бичиг, санал тооллого, шийдвэрийн бүртгэлийг бүрэн хөтлөх.

1.6. Энэхүү Түр журам нь мэргэжлийн зөвлөлүүдийн үндсэн журамд нэмэлт, өөрчлөлт оруулахгүй бөгөөд тухайн зөвлөлийн гишүүдийн тоо, сонгох эрх, нэр дэвшигчид тавигдах тусгай шаардлага, бүрэн эрхийн хугацаа болон бусад зохицуулалтыг өөрчлөх үндэслэл болохгүй.

ХОЁР. Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулах

2.1. Мэргэжлийн зөвлөлүүдийг байгуулах сонгуулийн ажлыг Холбооны Удирдах зөвлөлийн шийдвэрээр зохион байгуулна.

2.2. Удирдах зөвлөл нь сонгуулийн ажлыг зохион байгуулахдаа дараах асуудлыг шийдвэрлэнэ:

2.2.1. Сонгууль явуулах мэргэжлийн зөвлөлүүдийн жагсаалтыг тодорхойлох;

2.2.2. Сонгуулийн нэгдсэн хуваарь, зохион байгуулалтын төлөвлөгөөг батлах;

2.2.3. Зөвлөлийн сонгуулийн ажлын зохион байгуулах Сонгуулийн комиссыг байгуулах;

2.2.4. Сонгуулийн дүнг хэлэлцэж, Холбооны Дүрэм болон холбогдох журмын дагуу баталгаажуулах.

2.3. Сонгуулийн комисс нь тухайн мэргэжлийн зөвлөлийн журамд өөрөөр заагаагүй бол гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Комиссын бүрэлдэхүүнийг Удирдах зөвлөлийн шийдвэрээр тогтооно.

2.4. Сонгуулийн комиссын гишүүн нь тухайн сонгуульд нэр дэвшигч байхгүй, ашиг сонирхлын зөрчилгүй, сонгуулийн үйл ажиллагааг шударгаар зохион байгуулах боломжтой байна.

2.5. Сонгуулийн комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

2.5.1. Сонгуулийн хуваарийг батлах;

2.5.2. Нэр дэвшүүлэх болон сонгуулийн мэдээллийг холбогдох гишүүдэд хүргэх;

2.5.3. Нэр дэвшигчдийн материалыг хүлээн авч бүртгэх;

2.5.4. Нэр дэвшигчид тухайн зөвлөлийн журмын шаардлага хангаж байгаа эсэхийг шалгах;

2.5.5. Сонгогчдын нэрсийн жагсаалт, саналын хуудсыг бэлтгэх;

2.5.6. Санал хураалт, санал тооллогыг зохион байгуулах;

2.5.7. Сонгуулийн дүнгийн протокол үйлдэх;

2.5.8. Сонгуулийн баримт бичгийг эмхэтгэн Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргад хүлээлгэн өгөх;

2.5.9. Сонгуультай холбоотой өргөдөл, гомдлыг хүлээн авч, эрх хэмжээнийхээ хүрээнд шийдвэрлэх буюу холбогдох бүтцэд уламжлах.

2.6. Сонгуулийн комиссын гишүүд нэр дэвшигчийг ил, далд хэлбэрээр дэмжих, сонгогчдод нөлөөлөх, сонгуулийн дүнг өөрчлөх аливаа үйлдэл гаргахыг хориглоно.

ГУРАВ. Сонгуулийн хуваарь, мэдээлэл хүргүүлэх

3.1. Сонгуулийн комисс нь Удирдах зөвлөлөөс баталсан хуваарийн дагуу сонгуулийн ажиллагааг зохион байгуулна.

3.2. Сонгуулийн тухай мэдэгдэлд дараах мэдээллийг тусгана:

3.2.1. Байгуулах мэргэжлийн зөвлөлийн нэр;

3.2.2. Зөвлөлийн гишүүний тоо, бүрэлдэхүүнд тавигдах шаардлага;

3.2.3. Нэр дэвшүүлэх эрх бүхий этгээд, нэр дэвшүүлэх журам;

3.2.4. Нэр дэвшигчийн материал хүлээн авах эхлэх, дуусах хугацаа;

3.2.5. Нэр дэвшигчийн бүрдүүлэх баримт бичиг;

3.2.6. Сонгууль явуулах өдөр, цаг, хэлбэр, байршил;

3.2.7. Сонгогчдын бүртгэл, санал хураалтын журам;

3.2.8. Өргөдөл, гомдол хүлээн авах хаяг, хугацаа.

3.3. Сонгуулийн тухай мэдэгдлийг Холбооны албан ёсны цахим хуудас, цахим шуудан болон бусад боломжит сувгаар холбогдох гишүүдэд хүргүүлнэ.

ДӨРӨВ. Нэр дэвшүүлэх, бүртгэх

4.1. Мэргэжлийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх ажиллагааг тухайн зөвлөлийн журмаар тогтоосон эрх бүхий этгээд, шаардлага, шалгуурын дагуу явуулна.

4.2. Нэр дэвшигч нь тухайн зөвлөлийн журамд заасан мэргэжлийн болон бусад шаардлагыг хангасан байна.

4.3. Зөвлөлийн бүрэлдэхүүнд аль нэг клуб, байгуулагын төлөөлөл нэгээс илүүгүй байна.

4.4. Нэр дэвшигчээс дараах материалыг шаардаж болно:

4.3.1. Нэр дэвшигчийн анкет;

4.3.2. Мөрийн хөтөлбөр;

4.3.3. Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт;

4.3.4. Тухайн зөвлөлийн журмаар шаардсан бусад баримт бичиг.

4.5. Сонгуулийн комисс нэр дэвшигчийн материалыг шалгаж, шаардлага хангасан нэр дэвшигчийг бүртгэнэ.

4.6. Нэр дэвшигчийг бүртгэхээс татгалзсан тохиолдолд татгалзсан үндэслэлийг тухайн нэр дэвшигчид мэдэгдэнэ.

4.7. Нэр дэвшигчдийн эцсийн жагсаалтыг санал хураалт эхлэхээс өмнө сонгогчдод танилцуулна.

4.8. Нэр дэвшигч бүрт өөрийн мэргэжлийн туршлага, зорилго, ажлын саналыг сонгогчдод танилцуулах тэгш боломж олгоно.

ТАВ. Сонгогчдын бүртгэл, санал хураалт

5.1. Сонгуульд оролцох эрх бүхий сонгогчдыг тухайн мэргэжлийн зөвлөлийн журмын дагуу тодорхойлж, бүртгэнэ.

5.2. Сонгуулийн комисс сонгогчдын нэрсийн жагсаалтыг урьдчилан бэлтгэж, сонгуульд оролцох эрхийг шалгана.

5.3. Зөвлөлийг байгуулах хуралд Холбооны гишүүн байгууллага клубээс нэг төлөөлөл саналын эрхтэй оролцоно.

5.4. Зөвлөлийг байгуулах хурлын төлөөлөгч нэгээс илүү клуб, байгууллагыг төлөөлөхгүй.

5.5. Санал хураалтыг тухайн зөвлөлийн журмаар тогтоосон хэлбэрээр явуулна. Нууц санал хураалт явуулахаар заасан бол сонгогчийн сонголтын нууцлалыг бүрэн хангана.

5.6. Сонгуулийн комисс саналын хуудсыг бэлтгэж, олгосон болон ашигласан саналын хуудасны тоог бүртгэнэ.

5.7. Сонгогч нь тухайн зөвлөлийн журам болон саналын хуудсанд заасан зааврын дагуу саналаа өгнө.

5.8. Санал хураалтыг дуусмагц саналын хуудсыг хурааж, тооллогыг сонгуулийн комисс зохион байгуулна.

ЗУРГАА. Санал тоолох, сонгуулийн дүн гаргах

6.1. Санал тооллогыг ил тод, нээлттэй, баримтжуулсан хэлбэрээр явуулна. Саналын нууцлалыг задруулахгүй.

6.2. Санал тоолох үед дараах ажиллагааг гүйцэтгэнэ:

6.2.1. Саналын хуудсыг хүлээн авч тоолох;

6.2.2. Хүчинтэй болон хүчингүй саналын хуудсыг ялгах;

6.2.3. Нэр дэвшигч тус бүрийн авсан саналыг тоолох;

6.2.4. Тооллогын дүнг тулган баталгаажуулах;

6.2.5. Санал тооллогын протокол үйлдэх.

6.3. Нэр дэвшигчдийг сонгогдсонд тооцохдоо тухайн зөвлөлийн журамд заасан гишүүдийн тоо, саналын босго, эрэмбэ болон бусад шалгуурыг баримтална.

6.4. Санал тэнцсэн, саналын хуудас хүчингүй болсон, сонгуульд шаардлагатай тооны нэр дэвшигч оролцоогүй зэрэг асуудлыг тухайн зөвлөлийн журамд заасны дагуу шийдвэрлэнэ.

6.5. Сонгуулийн комисс нь сонгуулийн дүнгийн протоколд дараах мэдээллийг тусгана:

6.5.1. Сонгууль явуулсан огноо, байршил, хэлбэр;

6.5.2. Сонгуулийн комиссын бүрэлдэхүүн;

6.5.3. Сонгогчдын бүртгэлийн тоо, санал өгсөн сонгогчдын тоо;

6.5.4. Хүчинтэй болон хүчингүй саналын тоо;

6.5.5. Нэр дэвшигч тус бүрийн авсан санал;

6.5.6. Сонгогдсон нэр дэвшигчдийн нэрс;

6.5.7. Маргаан, гомдол гарсан бол түүний талаарх тэмдэглэл;

6.5.8. Комиссын гишүүдийн гарын үсэг.

6.6. Сонгуулийн комисс сонгуулийн дүнг Удирдах зөвлөлд албан ёсоор танилцуулна.

ДОЛОО. Зөвлөлийн даргыг сонгох, бүрэлдэхүүнийг баталгаажуулах

7.1. Зөвлөлийн даргыг зөвлөлийн гишүүд дотроосоо сонгож, сонгуулийн үр дүнг Удирдах зөвлөлөөр баталгаажуулах зохицуулалтыг мөрдөнө.

7.2. Зөвлөлийн гишүүдийн сонгуулийн дүн болон зөвлөлийн даргын сонголтыг холбогдох журмын дагуу баталгаажуулсны үндсэн дээр Удирдах зөвлөлд танилцуулна.

7.3. Удирдах зөвлөл нь Холбооны Дүрэмд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд сонгуулийн дүнг хэлэлцэж, шаардлагатай шийдвэрийг гаргана.

7.4. Сонгуулийн үр дүнг баталгаажуулсны дараа Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга тухайн зөвлөлийн бүрэлдэхүүн, дарга, бүрэн эрхийн хугацаа болон холбогдох мэдээллийг Холбооны бүртгэлд оруулж, гишүүдэд мэдэгдэнэ.

7.5. Зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа, улиран сонгогдох боломж болон бүрэн эрх дуусгавар болох үндэслэлийг тухайн зөвлөлийн журамд заасны дагуу тогтооно.

НАЙМ. Өргөдөл, гомдол, маргаан шийдвэрлэх

8.1. Сонгуулийн ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлыг сонгуулийн комисст бичгээр эсхүл цахим хэлбэрээр гаргана.

8.2. Өргөдөл, гомдолд маргаан бүхий асуудал, түүний үндэслэл, боломжтой бол нотлох баримтыг тусгана.

8.3. Сонгуулийн комисс нь өөрийн эрх хэмжээний хүрээнд өргөдөл, гомдлыг хянан үзэж, үндэслэл бүхий хариу өгнө. Комиссын эрх хэмжээнээс хэтэрсэн, эсхүл комиссын үйл ажиллагаатай холбоотой гомдлыг Удирдах зөвлөл болон Холбооны Дүрэмд заасан эрх бүхий байгууллагад шилжүүлнэ.

8.4. Гомдол гаргасан нь сонгуулийн үйл ажиллагааг зогсоох үндэслэл болохгүй. Сонгуулийг түр зогсоох, хүчингүй болгох, дахин явуулах асуудлыг зөвхөн эрх бүхий байгууллага холбогдох дүрэм, журмын дагуу шийдвэрлэнэ.

8.5. Сонгуулийн ажиллагаанд ноцтой зөрчил гарч, үр дүнд бодитой нөлөөлсөн нь тогтоогдвол эрх бүхий байгууллага тухайн зөрчлийг арилгах, дахин санал хураалт явуулах эсхүл бусад зохих арга хэмжээ авах шийдвэр гаргана.

ЕС. Баримт бичиг, мэдээллийн ил тод байдал

9.1. Сонгуулийн комисс нь сонгуулийн явцад үүссэн баримт бичгийг бүрэн бүрдүүлж, Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

9.2. Сонгуулийн баримт бичигт дараах материалыг хамруулна:

9.2.1. Удирдах зөвлөлийн сонгууль зохион байгуулах шийдвэр;

9.2.2. Сонгуулийн комисс байгуулах шийдвэр;

9.2.3. Сонгуулийн хуваарь, мэдэгдэл;

9.2.4. Нэр дэвшигчдийн материал, бүртгэл;

9.2.5. Сонгогчдын нэрсийн жагсаалт;

9.2.6. Саналын хуудас болон санал тооллогын протокол;

9.2.7. Сонгуулийн дүнгийн тухай шийдвэр;

9.2.8. Өргөдөл, гомдол болон тэдгээрийн шийдвэрлэлттэй холбоотой материал.

9.3. Удирдах зөвлөл Сонгуулийн дүн болон сонгогдсон зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталгаажуулсны дараа мэдээллийг Холбооны албан ёсны мэдээллийн сувгаар нийтэд мэдээлж болно. Хувийн мэдээлэл болон саналын нууцлалыг хамгаална.

АРАВ. Бусад зүйл

10.1. Энэхүү Түр журмаар зохицуулаагүй асуудлыг Холбооны Дүрэм, тухайн мэргэжлийн зөвлөлийн журам болон Удирдах зөвлөлийн холбогдох шийдвэрээр зохицуулна.

10.2. Энэхүү Түр журам болон мэргэжлийн зөвлөлийн журмын хооронд зөрчил үүссэн тохиолдолд Холбооны Дүрэм, тухайн асуудлыг тусгайлан зохицуулсан мэргэжлийн зөвлөлийн журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.

10.3. Түр журамд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Холбооны Удирдах зөвлөл хэлэлцэж шийдвэрлэнэ.

10.4. Энэхүү Түр журам нь Холбооны Удирдах зөвлөлийн баталсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

ЕРӨНХИЙЛӨГЧ: _____ /Р.БАДРАХ/

Удирдах зөвлөлийн 2026 оны 10 сарын 23-ны
өдрийн № 16 тоот тогтоолын Хавсралт-3

Зураг

НЭР ДЭВШИГЧИЙН БҮРТГЭЛИЙН МАЯГТ

1. НЭР ДЭВШИГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

Сонгогдох албан тушаал: ☐ Тамирчны зөвлөл
☐ Дасгалжуулагчийн зөвлөл ☐ Шүүгчийн зөвлөл
Овог: _____
Нэр: _____
Төрсөн огноо: _____
Регистрийн дугаар: _____
Утас: _____
И-мэйл: _____
Оршин суугаа хаяг: _____

2. ЭРХЭЛЖ БУЙ АЖИЛ, АЛБАН ТУШААЛ

Клуб/ байгууллага: _____
Албан тушаал: _____

3 . БҮРДҮҮЛСЭН МАТЕРИАЛ

№	Материал	Байгаа	Байхгүй	Тайлбар
1	Нэр дэвшигчийн товч танилцуулга	☐	☐	
2	Мөрийн хөтөлбөр /хэрэв байгаа бол/	☐	☐	
3	Холбооны гишүүнчлэлийн татвар төлсөн эсэх: ☐ Тийм ☐ Үгүй /2026 оны 03 сарын 13-ны өдрийн УЗ-ийн № 04 тоот тогтоолоор тогтоосон татварын хэмжээг мөрдөнө. Дансны дугаар: MN28 0004000 450014950, ХХБанк, Монголын Усан Спорт Сонирхогчдын холбоо/			
4	Бусад шаардлагатай баримт бичиг /Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа эсэх тухай тодорхойлолт/	☐	☐	

4. НЭР ДЭВШИГЧИЙН БАТАЛГАА

Би дээр дурдсан мэдээлэл үнэн зөв болохыг баталж, Монголын Усан Спорт Сонирхогчдын Холбооны дүрэм, журмын шаардлагыг дагаж мөрдөхөө баталж байна. Нэр дэвшигчийн бүртгэлийн маягтыг secretariat@mongoliaaquatics.mn мэйл хаягаар 2026 оны 11 сарын 12-ны 18:00 цагаас өмнө илгээнэ.

Нэр дэвшигч: _____
Гарын үсэг: _____

Огноо: 2026 оны ___ сарын ___ өдөр

МУССХ-ны УЗ-ийн 2026 оны 10 сарын 23-ны өдрийн
№16 тоот тогтоолын Хавсралт-4

Зураг

МОНГОЛЫН УСАН СПОРТ СОНИРХОГЧДЫН ХОЛБООНЫ

ЗӨВЛӨЛҮҮДИЙГ СОНГОХ ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН АНКЕТ

(Зөвлөлийн нэр . . . . . .)

Эцэг (эх)-ийн нэр : ..... Өөрийн нэр : .....

Төрсөн ..... он ..... сар ..... өдөр Хүйс: .....

Төрсөн аймаг, хот ..... сум, дүүрэг ..... Хороо .....

Регистерын №		И-мэйл хаяг:	
Харилцах утас:		Яаралтай холбогдох утас:	
Төлөөлж буй клуб байгууллагын нэр:			

МУССХ-ны Удирдах зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийг сонгох хурлын төлөөлөгч миний бие Холбооны дүрэм журмын хүрээнд, ёс зүйн хэм хэмжээг чанд мөрдөн, хэн нэгний шахалт дарамтад авталгүй, өөрийн итгэл үнэмшил сонголтоор хурлын бүхий л үйл ажиллагаанд оролцоно.

Гарын үсэг: .....

Огноо: .....